



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 704

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 61,788,774.9 (жаран нэгэн сая долоон зуун наян найман мянга долоон зуун далан дөрвөн төгрөг ерэн мөнгө) төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь

1. “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал (Б.Түмэн-Өлзий)-д Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

3. “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал (Б.Түмэн-Өлзий)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

3.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

3.2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” 332 дугаар тогтоолын 3.2, 3.8 дахь заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах;

3.3. Уран бүтээлийн хувцас, тоног төхөөрөмж, жижиг хэрэглэлийг иргэн, хуулийн этгээдэд түрээсийн гэрээгээр төлбөртэй ашиглуулах, үнэ тарифыг шинэчлэн тогтоох;

3.4. Төрийн өмчид бүртгэлгүй, үнэлээгүй, 6 нэр төрлийн, 60 ширхэг (Соёлын яамнаас өгсөн) камерын төхөөрөмж, аж ахуйн аргаар барьсан 4 ширхэг автомашины гараашийг үнэлж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу шийдвэрлүүлэх;

3.5. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 61 нэр төрлийн, 237,914,788.22 (хоёр зуун гучин долоон сая есөн зуун арван дөрвөн мянга долоон зуун наян найман төгрөг хорин хоёр мөнгө) төгрөгийн хөрөнгөнөөс цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийг ялган үнийг шинэчлэн тогтоох, ашиглах боломжгүй үндсэн хөрөнгийг

акталж данснаас хасах асуудлыг Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

3.6.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу бараа материал, хангамжийн зүйлсийн бүртгэлийг хөтлөх;

3.7.Төрийн өмчийн барилга байгууламжийн хөрөнгө оруулалт, ашиглалт, эрүүл ахуйн нөхцөл байдлыг сайжруулах асуудлыг эрх бүхий байгууллагад танилцуулах;

3.8.Худалдан авах үйл ажиллагааны батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй эд хөрөнгө олж бэлтгэхгүй байх;

3.9.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2024 оны 12 дугаар сарын 13-ны
өдрийн 10.1 дугаар тогтоолын хавералт

“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газарт
хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал,
түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн (төгрөгөөр)	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Бараа материал, хангамжийн зүйлсийн хөдлөл өөрчлөлт, үлдэгдлийн бүртгэлийг хуулийн дагуу хөтөлж, данс бүртгэлд тусгаагүй	33,457,299.45	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, Соёлын салбарын “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн 2.3.4 дэх заалтыг мөрдөж ажиллах.
2	Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн	28,331,475.45	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11.8 дахь заалтыг мөрдөж ажиллах.
Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн нийт дүн		61,788,774.90 (жаран нэгэн сая долоон зуун наян найман мянга долоон зуун далан дөрвөн төгрөг ерэн мөнгө) төгрөг	